**ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ**

Байгууллагын нэр: **Нийслэлийн Хөдөлмөр эрхлэлтийн газар**

Огноо: 2019.06.20

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин /тоо хэмжээ, хувь/ | Хүрсэн түвшин /хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ/ | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр /мян.төг/ | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.Хүний нөөцийг чадавхжуулах | 1 | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | Дотоод сургалтын тоо | 5-аас дээш | Байгууллага дотооддоо 5 төрлийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 50 албан хаагчийг 92 цагийн хамруулсан байна. Үүнд:<br>1. Засгийн газрын 2018 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх хүүхэд, гэр бүл рүү чиглэсэн тодорхой ажил зохион байгуулах үүрэг бүхий байгууллагын "Эцэг эхийн зөвлөл"-ийг газрын даргын 2018 оны А/46 дугаар тушаалаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд тус зөвлөлийн 2019 онд хийх ажлын | 1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан-4.000.000 /Ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх, Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх/<br><br>2.Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх зардал-600.000 /А3 сургалт/ | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн холбогдох зардлаар "Сантис" сургалтын төвтэй хамтран албан хаагчийг англи хэлний сургалтад хамруулах 6.000.000 төгрөгийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 2018 онд 6 албан хаагчийг сургалтад хамруулсан бөгөөд 2019 онд үлдсэн санхүүжилтээр албан хаагчдыг сургаж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | төлөвлөгөөний дагуу Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газартай хамтран Сургуулийн нийгмийн ажилтнуудын нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргалыг урьж 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр “Хүүхэд хүмүүжүүлэн сургах ухааны уламжлал ба шинэчлэл” сэдвээр албан хаагчдад зориулан сургалт зохион байгууллаа.<br>2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2019 оны А/263 тушаалаар батлагдсан хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад мэргэшсэн сургалтыг зохион байгуулах, гэрчилгээ олгох арга зүйн зөвлөмжийн дагуу Монголын хүний нөөцийн менежментийн холбооноос зохион байгуулсан “Ажилд зуучлах үйлчилгээний мэргэшсэн зөвлөх” бэлтгэх 12 модульт сургалтад тус газрын 10 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.<br>3. Монголын хүний нөөцийн менежментийн холбооноос зохион байгуулсан “Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөх” бэлтгэх 5 модульт сургалтад тус газрын 7 албан хаагч хамрагдаж гэрчилгээ авсан.<br>4. Байгууллагын албан хаагчдад Нийслэлийн дотоод удирдлагын “UB ERP” системийн танилцуулга сургалтыг 2019.06.14-ны өдөр зохион | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгуулсан.<br>5. Албан хаагчдын гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор "Сантис" сургалтын төвтэй хамтран 3 албан хаагчийг англи хэлний сургалтад хамруулж байна. Энэ онд дахин 6 албан хаагчийг сургахаар төлөвлөсөн.<br>90% | | |
| | | | Албан хаагчдын хамрагдсан байдал | 80 хувиас дээш | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх дотоодын сургалтад давхардсан тоогоор албан хаагчдын 90-ээс дээш хувь хамрагдсан.<br>100% | | |
| | | | Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал | 20 хувиас дээш | Эхний хагас жилийн байдлаар албан хаагчид гадаад сургалтад хамрагдаагүй байна.<br>- | | |
| | 2 | Мэргэшсэн туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх | 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | 70 хувиас дээш | Нийт албан хаагчдын 80 хувь нь 3 болон түүнээс дээш ажилласан, мэргэшсэн туршлагатай боловсон хүчнүүд байна.<br>100% | | |
| **Хэсгийн дундаж: 96.7 %** | | | | | | | |
| 2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | 3 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо | Гүйцэтгэлээр | Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний салбарын ажилтны өдрийг тохиолдуулан салбартаа үр бүтээлтэй ажилласан Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Г.Ганзориг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны "Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан" цол тэмдгээр, мэргэжилтэн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Д.Эрдэнэбилэг, Д.Очирсүрэн нар ХХҮЕГ-ын даргын "Хүндэт өргөмжлөл"-өөр, мэргэжилтэн Л.Норов Нийслэлийн Засаг даргын шагнал "Нийслэлийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр, мэргэжилтэн Б.Сайнжаргал, Б.Болормаа нар Монголын залуучуудын холбооны "Тэргүүний залуу" медалиар тус тус шагнагдсан байна. 90% | | |
| | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах | Гүйцэтгэлээр | УИХ-ын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан"Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгох журам"-ын дагуу Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлд зэрэг дэв шинээр олгуулах болон зэрэг дэв ахиулах албан хаагчдын судалгааг хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/491 дүгээр захирамжийн дагуу Сургалт, судалгааны хэлтсийн дарга С.Нямдорж, эрх зүй, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн Т.Одонтогоо нарт зэрэг дэвийг шинээр олгож, Хөдөлмөр эрхлэлтийн хэлтсийн дарга Г.Ганзориг, мэргэжилтэн С.Уугантуяа, Н.Одонтуяа, Б.Сайнжаргал нарын зэрэг дэвийг ахиулж, нэмэгдлийг Газрын даргын 2019 оны А/26 дугаар тушаалын дагуу 2019.05.01-ний өдрөөс олгож эхлээд байна. 90% | | |
| | 4 | Албан хаагчдын ажлын | Ажлын байрны таатай орчны | Сэтгэл ханамж 80 хувиас дээш | Байгууллагын албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг хангаж ажиллаж байна. Ажлын | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал | сэтгэл ханамжийн санал асуулга | | байрны таатай орчныг ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгаагаар 85-аас дээш хувьтай байна. 90% | | |
| | | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх | Гүйцэтгэлээр | Албан хаагчид сар бүрийн үндсэн цалин дээр унаа хоолны нэмэгдлийг авч байна. 100% | | |
| | 5 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | Жилд 1-ээс доошгүй удаа | Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн хүрээнд зохион байгуулж буй "Хүн амын бие бялдрын хөгжилт, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын сарын аян"-ны хүрээд тус газрын 9 албан хаагчаас бие бялдрын сорил авч, мэдээг холбогдох сайтад шивж, нэгтгэсэн болно. 90% | | Албан хаагчдыг төлөвлөгөөний дагуу 2019 оны 09 дүгээр сард эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт нэгдсэн журмаар хамруулахаар төлөвлөөд байна. |
| | | | Албан хаагчдын хамрагдалт | 100 хувь | - | | |
| **Хэсгийн дундаж: 92 %** | | | | | | | |
| **Үнэлгээний дундаж хувь: 94.3%** | | | | | | | |

ТАНИЛЦСАН:

ДАРГА П.БАТХҮЛЭГ

ХЯНАСАН:

ХЭЛТСИЙН ДАРГА Г.ГАНТҮШИГ

НЭГТГЭСЭН:

МЭРГЭЖИЛТЭН Т.ОДОНТОГОО